



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ

2014 оны 8 дугаар
сарын 14-ний өдөр

Дугаар 97

Улаанбаатар
хот

Ажлын хэсэг байгуулах тухай

1. НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөр 2015 онд хэлэлцүүлэх Монгол Улс дахь Хүний эрхийн төлөв байдлын талаарх Үндэсний 2 дугаар илтгэл бэлтгэх Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

- | | |
|---------|---|
| Ахлагч | -Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн дарга |
| Орлогч | -Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга |
| Гишүүд: | <ul style="list-style-type: none">-Цагдаагийн ерөнхий газрын дарга;-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга;-Хүүхдийн төлөө үндэсний газрын дарга;-Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга;-Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны ахлах референт;-Улсын Ерөнхий прокурорын газрын Эрх зүйн туслалцаа, гадаад харилцааны хэлтсийн дарга;-Сонгуулийн ерөнхий хорооны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга;-Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын захирал;-Гадаад харилцааны яамны Олон улсын байгууллагын газрын захирал;-Хууль зүйн яамны Хууль зүйн нэгдсэн бодлогын газрын дарга;-Сангийн яамны Хууль, худалдан авах ажиллагааны бодлогын газрын дарга;-Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга; |

- Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга;
- Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;
- Эдийн засгийн хөгжлийн яамны Хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлт, зохицуулалтын газрын дарга;
- Хөдөлмөрийн яамны Хөдөлмөрийн харилцааны бодлого зохицуулалтын газрын дарга;
- Боловсрол, шинжлэх ухааны яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга;
- Соёл, спорт, аялал жуулчлалын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга;
- Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга;
- Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга;
- Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга;
- Хууль зүйн яамны Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга;
- НҮБ-ын Женев дэх салбар болон олон улсын бусад байгууллагын дэргэд суугаа Байнгын төлөөлөгч;
- Жендерийн үндэсний хорооны Ажлын албаны дарга;
- Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл (тохиролцсоноор).

Нарийн бичгийн дарга:

- Хууль зүйн яамны Хүний эрхийн асуудал эрхэлсэн ажилтан;
- Гадаад харилцааны яамны Хүний эрхийн асуудал хариуцсан ажилтан;
- Женев дэх Байнгын төлөөлөгчийн газрын Хүний эрхийн асуудал хариуцсан ажилтан.

2. Монгол Улс дахь Хүний эрхийн төлөв байдлын талаарх Үндэсний 2 дугаар илтгэлийг боловсруулж 2014 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн дотор Засгийн газарт танилцуулахыг Ажлын хэсэгт даалгасугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Н.АЛТАНХУЯГ

